

Бохир соруулах машинд гал гарах, дэлбэрэх аюултай!

2020 оны 03-р сар



Бохир соруулдаг машин

Бохир соруулдаг машины ослын зураг

(Санта Кларагийн бохир усны байгууламжид тохиолдсон дэлбэрэлт)



2014 оны 11-р сарын 18-ны өдөр Санта Паула (Өмнөд Калифорни) хотын бохир ус цэвэрлэх байгууламжид бохир соруулах машин дэлбэрсний улмаас хорт бодис талбайд шүршигдэж, хэдэн арван хүн (гурван гал сөнөөгчийн хамт) эмнэлэгт хүргэгджээ.

Тус гамшгаас хойш хэдэн сарын турш **натри хлорид** буюу исэлдүүлэгч бодис илэрсэн байна. Энэхүү химийн бодисыг ус цэвэрлэх зорилгоор анх удаа хэрэглэсэн аж. Материал устгахад ашигладаг уг бодисыг машин руу соруулж оруулахад бусад бодистой холилдооны улмаас тэсрэлт үүсч, машины арын хэсэг дэлбэрсэн бөгөөд доторх материал талбай дээгүүр шүршигджээ. Улмаар алдагдсан материал хатсаны дараа шатаж эхэлсэн байна. Дэлбэрэлтээр эргэн тойрны контейнерүүдэд гал тархаж, тэнгэрт хар утаа дэгдсэн ба цагдаа нар хэд хэдэн замыг хаах шаардлагатай болсон. Мөн нэг милийн зай доторх оршин суугчдыг хүчээр нүүлгэн шилжүүлж, гурван милийн зай доторх оршин суугчдад байрнаасаа гарахгүй байх зааварчилгаа өгсөн.

Та мэдэх үү?

- Бохир соруулах машин руу тохиромжгүй материал шахсаны улмаас гал болон дэлбэрэлт үүсэх аюултай.
- Шатамхай шингэнтэй холбоотой бусад эрсдэл:
 - Бохир соруулах машин нам даралтаар ажилладаг учир нам температурт буцалсан материал ууршиж болзошгүй. Тэрхүү уур нь машины агааржуулалтын системээр гадагшилж гал ноцоох эрсдэлтэй.
 - Бохир соруулах машин шингэн бодис болон агаарыг дотогш сорсноор машины ууршилттай хэсэгт шатамхай бодисууд холилдож, улмаар шингэн бодис болон агаарын нэгдлээс статик цэнэг үүсэх нөхцөл бүрддэг.
 - Бохир соруулах машины дотор материал холилдох, зайлагдах нь статик цэнэг үүсгэдэг гол процесс юм.

Та юу хийж чадах вэ?

- Олон компани бохир соруулах машины аюулгүй ажиллагааг хянахын тулд зөвшөөрөл олгох системийг хэрэгжүүлдэг. Хэрэв та бохир соруулах машинтай ойр ажилладаг бол зөвшөөрлийн баримт дээрх бүх мэдээллийг бүрэн зөв мөрд..
- Бохир соруулах машин олон янзын эх үүсвэрээс материал соруулдаг. Соруулж эхлэхийн өмнө тухайн материал машин доторх материалтай нийцэх эсэхийг нягтал. Сайн мэдэхгүй бол ажлыг зогсоож, асууж тодруул.
- Бохир соруулах машин болон бусад ачаа ачиж, буулгаж буй тээврийн хэрэгслийг газардуулсан эсэхийг баталгаажуул.
- Бохир соруулах машиныг хаана ч ашигладаг. Хэрэв ууршсан шатамхай бодис агааржуулалтаар гадагшилж болзошгүй бол ямар нэгэн галын эх үүсвэртэй нэгдэхээс сэргийл.

Бохир соруулах машинд онцгой анхаарал шаардлагатай.

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE –с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Бидэнтэй ccps_beacon@aiiche.org эсвэл 646-495-1371 хаягаар холбогдоно уу.

Beacon –Үйлдвэрлэлийн Аюулгүй Ажиллагааны Сануулга ихэвчлэн Африк, Араб, Катар, Хятад, Чех, Дани, Голланд, Англи, Филиппин, Франц, Герман, Грек, Гуэжарати, Еврей, Хинди, Индонези, Итали, Япон, Солонгос, Малай, Марати, Монгол, Перси, Польш, Португали, Роман, Орос, Испани, Швед, Тэлугу, Тайланд, Турк болон Вьетнам хэл дээр гарсан байна.